



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 06 сарын 09 өдөр

Дугаар А/336

Есөнбулаг сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Биеийн тамир, спортын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.9 дэх заалт, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2026 оны 9 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Говь-Алтай аймгийн Эрдэнэ суманд 2026 оны 06 дугаар сарын 13-15-ны өдрүүдэд зохион байгуулагдах "Баруун бүсийн зуун буудалт даамын аварга шалгаруулах тэмцээн"-нд зардлын дэмжлэг үзүүлсүгэй.

2. Тэмцээнийг зохион байгуулах зардалд шаардагдах 8,000,000 (найман сая) төгрөгийг аймгийн Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (М.Насанбат)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтийг хангаж, хөрөнгийн зарцуулалтын тайланг холбогдох журмын дагуу гаргаж, тайлагнахыг "Таргилж ханы даамчдын холбоо"-ны тэргүүн (Д.Балжинням)-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Ж.Амгаланбаатар), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ЧИНБАТ

